



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 6/02

Хэрлэн сум

Г.Тэмүүжинг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ганболдын Тэмүүжин нь төрийн албаны тусгай шалгалтад тэнцсэн тул Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын

дарга: Ч.Баярцолмон Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Ш.Эрдэнэжаргал Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

С.Чулуунцэцэг Нярав

3.Г.Тэмүүжингийн цалинг ТЗ-7 зэрэглэлээр тогтоон, 1,320,000 (нэг сая гурван зуун хорин мянга) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар тооцож олгохыг Нягтлан бодогч (Х.Баярбаатар)-д зөвшөөрсүгэй.

4.Нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол шийдвэрийн

2.

хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Г.Тэмүүжинд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА